

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.08.12 - 08.16

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтах өргөн хэрэглээний бараа болон ус, дулаан, цахилгаан хангамжийн салбарын компаниудын хувьцаа өсөлттэй байсан бол газрын тосны үнэ буурсантай холбоотой эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа уналттай байв.

Лхагва гарагт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн томоохон индексүүд энэ оны хамгийн их хэмжээний уналтыг үзүүллээ. Энэхүү уналтын гол шалтгаан нь 10 жилийн хугацаатай засгийн газрын бондын өгөөж буурч, 2 жилийн хугацаатай засгийн газрын бондын өгөөжөөс бага болсон явдал юм. Түүхэнд өгөөж ийнхүү буурах нь АНУ-д эдийн засгийн хямралыг дагуулж байжээ.

АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп 9-р сарын 1-ээс хэрэгжиж эхлэх байсан БНХАУ-ын импортын зарим бараа бүтээгдэхүүнд ногдуулах гаалийн татварын арга хэмжээний хэрэгжиж эхлэх хугацааг 12 сарын дунд үе хүртэл хойшлуулжээ. Тэрбээр баярын үеийн худалдан авалтад ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүйн тулд энэхүү шийдвэрээ гаргасан хэмээн тайлбарласан нь гаалийн татварын арга хэмжээ АНУ-ын хэрэглэгчдэд үнийн дарамт учруулна гэдгийг шууд бусаар хүлээн зөвшөөрсөн явдал болжээ.

Европ: АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргаан болон Европын бүсийн эдийн засгийн хямрал ойртож байгааг илтгэх дохионууд илэрсэнтэй холбоотойгоор Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа.

Евро бүсийн эдийн засаг 2019 оны 2-р улиралд маш багаар буюу 0.2%-аар өслөө. Бүсийн хамгийн том эдийн засаг болох ХБНГУ-ын эдийн засаг 0.1%-аар буурсан гэдгийг статистикийн Destatis агентлаг мэдээлэв.

АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргаан даамжирч, Европын орнуудын экспортод нөлөөлжээ. Европын холбооны орнуудын экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.6 хувиар буурсан нь сүүлийн 6 жилд үзэгдээгүй их хэмжээний уналт болжээ. Дэлхийн бусад орнууд руу гаргаж буй Евро бүсийн экспортын хэмжээ 4.7 хувиар буурсан бол БНХАУ руу гаргаж буй экспортын хэмжээ 3.4 хувиар буурчээ.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд гурван долоо хоног дараалан уналттай хаагдлаа.

Баасан гарагт Японы 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөж Японы төв банкны зорилтод өгөөж болох -0.20%-аас бага буюу -0.23%-д хүрч хаагдлаа. Японы төв банк цаашид ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй байна.

6-р сарын эцсийн байдлаар Япон улс АНУ-ын үнэт цаасыг эзэмшиж буй дүнгээр тэргүүлж байна. Япон улс 1.12 их наяд ам.доллартай тэнцэх АНУ-ын үнэт цаас эзэмшиж байгаа нь нийт АНУ-ын гаргасан үнэт цаасны 16.9%-ийг бүрдүүлж байгаа юм.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. БНХАУ-ын эрх баригчид удааширч буй эдийн засгаа идэвхжүүлэх үүднээс ирэх хоёр жилд илүүц орлогыг нэмэгдүүлэн дотоодын хэрэглээг дамжих арга хэмжээ авна гэдгээ илэрхийлсэн нь энэхүү өсөлтийг шалтгаан болов.

АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргаантай холбоотойгоор 7-р сард БНХАУ-ын үйлдвэлзлийн гарц болон жижиглэнгийн худалдаа шинжээчдийн таамаглаж байснаас бага дүнгээр өсжээ. Гэхдээ БНХАУ-ын эрх баригчид худалдааны маргаанаас үүсэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг авч эхэлж байгаа ба 9-р сард Вашингтон хотод зохион байгуулагдахдээ хэмжээний уулзатад оролцох хэвээр гэдгээ илэрхийлсэн юм.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,995.21	-1.96% ▼
Dow Jones	АНУ	25,886.01	-1.53% ▼
S&P 500	АНУ	2,888.68	-1.03% ▼
Nasdaq	АНУ	7,895.99	-0.79% ▼
S&P/TSX	Канад	16,149.79	-1.17% ▼
FTSE 100	Их Британи	7,117.15	-1.88% ▼
S&P/ASX 200	Австрали	6,405.50	-2.72% ▼
Nikkei 225	Япон	20,418.81	-1.29% ▼
Hang Seng	Хонг Конг	25,734.22	-0.79% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	111.18
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	100.04
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	99.48
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.65
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.20
DBM' 2023	USD	7.250%	102.00
TDBM' 2020	USD	9.375%	102.82

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.172	-0.02 ▼
Libor 3M	2.136	-0.04 ▼
Libor 6M	2.017	-0.04 ▼
Libor 1YR	1.945	-0.04 ▼
US 2YR Bond	1.491	-0.16 ▼
US 3YR Bond	1.446	-0.14 ▼
US 5YR Bond	1.435	-0.14 ▼
US 10YR Bond	1.583	-0.16 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.08.16	Өөрчлөлт
USD	2,672.87	0.15% ▲
CNY	379.38	0.24% ▲
EUR	2,962.61	-0.79% ▼
RUB	40.47	-0.93% ▼
KRW	2.21	0.45% ▲
JPY	25.18	-0.04% ▼
CAD	2,008.32	-0.49% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,513.52	1.11% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	17.11	0.79% ▲
Зэс	USD/lb.	259.50	0.23% ▲
Нүүрс	USD/MT	68.05	-5.62% ▼
WTI газрын тос	USD/bbl.	54.87	0.68% ▲
Brent газрын тос	USD/bbl.	58.64	0.19% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.20	3.77% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. VI	8.10%
Бодлогын хүү	2019. VI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. VI	11.13%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. VI	11.48%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. VI	4.95%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. VI	17.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. VI	10.68%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 44 компанийн 284.2 сая төгрөгийн 779,330 ширхэг хувьцаа арилжаалагдав.


“Улсын их дэлгүүр” /UID/ компанийн хувьцаа 36.72%-аар буюу хамгийн ихээр өсөж 700.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Ард санхүүгийн нэгдэл” /AARD/ компанийн хувьцаа 22.93%-аар буурч 1,499.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 249 ширхэг үнэт цаас 25.3 сая төгрөгөөр арилжаалагджээ.


8-р сарын 16-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,536.5 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,995.21 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.96%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	309.4
Зах зээлийн үнэлгээ	2,536,469.5

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,995.21	-1.96% ▼
MSE I индекс	9,225.77	-1.11% ▼
MSE II индекс	7,905.69	-1.91% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард санхүүгийн нэгдэл	42,023	69,017,262
Инвескор ББСБ	16,268	30,359,930
АПУ	55,111	29,877,603
Говь	86,543	25,541,558
Хөвсгөл алтан дуулга	32,992	23,307,059

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Улсын их дэлгүүр	700.00	36.72% ▲
Багануур	1,280.00	27.87% ▲
Могойн гол	7,500.00	20.97% ▲
Ремикон	28.00	6.79% ▲
Баянгол зочид буудал	28,100.00	4.07% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ард санхүүгийн нэгдэл	1,499.00	-22.93% ▼
Жуулчин дютти фрий	87,040.00	-20.44% ▼
Стандарт агрикалчер групп	120.00	-20.00% ▼
Өндөрхаан	1,923.00	-14.99% ▼
Мерекс	22.88	-10.27% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Голомт Капитал	136,881,823
Ард Секюритиз	135,378,146
Стандарт Инвестмент	62,907,736
Ти Ди Би Капитал	62,762,412
Бумбат-Алтай	57,810,683

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	531.25	565,346
Таван толгой	6,775.00	356,807
МИК Холдинг	13,900.00	287,860
Говь	292.99	228,565
Инвескор ББСБ	1,900.00	136,283

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-24/02/20-A0213-18	249	25,258,560	101,440	101,440	156	18.000%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.12-с

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Талх чихэр” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа

Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй “Талх чихэр” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр танилцууллаа. Тайлант хугацаанд:

-“Талх чихэр” ХК 25.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 751.1 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Борлуулалтын орлого 2018 оны мөн үеэс 5.2 тэрбум төгрөгөөр өсөж, ашигт ажиллагааны түвшин 0.75 болж өмнөх оны мөн үеэс 0.01 пунктээр өссөн байна.

-Олон улсын хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000:2005 стандартын гэрчилгээг баталгаажуулах шалгалтад орж, уг стандартыг амжилттай хэрэгжүүлж байгаагаа баталгаажуулжээ.

-ТОП-100 аж ахуйн нэгжид сүүлийн жилүүдэд тасралтгүй багтаж, Нийслэлийн шилдэг татвар төлөгч байгууллагаар шалгарсан байна.

-Нийгмийн хариуцлагын хүрээнд “Ухаалаг хэрэглэгч” хөтөлбөрийг амжилттай явуулсан байна.

-105 харилцагчтай түншийн гэрээ шинээр байгуулан ажилласны зэрэгцээ 3,000 харилцагчдыг нэгтгэсэн арга хэмжээг зохион байгуулсан.

-“Та Чи” бэйкери Хотол үйлдвэр, “Та Чи” Март 5-р салбарыг нээн ажиллуулж байна.

“Талх Чихэр” ХК энэ ондоо багтаан харилцагч хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүнүүдийн нэр төрлийг нэмэгдүүлэхээс гадна үйлдвэрийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийг шат дараалалтайгаар хийж байгаа тухай танилцууллаа.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Мандал даатгал” ХК 2019 оны хагас жилийн тайлангаа танилцууллаа

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй Мандал Даатгал ХК нь 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2019 оны 8-р сарын 14-ний өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд:

-2019 оны эхний хагас жилд “Мандал Даатгал” ХК-ийн хураамжийн орлого 18.2 тэрбум төгрөгт хүрч зах зээлийн 18 хувийг эзэлж байна.

-Цэвэр ашиг 3.4 тэрбум төгрөгт хүрсэн нь даатгалын салбарт тэргүүлэх үзүүлэлт бөгөөд үнэт цаасны танилцуулгад 2019 оны жилийн эцсээр олохоор төлөвлөсөн цэвэр ашгийн хэмжээг 100 хувь биелүүлсэн байна.

-Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал болон барилга угсралтын даатгалын хураамжийн орлогоор тэргүүлж байна.

“Мандал Даатгал” ХК-ийн нийт хөрөнгө 42.6 тэрбум төгрөгт хүрсэн нь дотоодын даатгалын зах зээлд хөрөнгийн хэмжээгээрээ тэргүүлж байна. Мөнгөн хөрөнгө оруулалтын хэмжээ 27.3 тэрбум төгрөгт хүрснээс Монголын хөрөнгийн зах зээлд 7.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт хийжээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Инвескор ББСБ” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа

Монголын хөрөнгийн бирж (МХБ)-ийн 3-р ангилалд бүртгэлтэй “Инвескор ББСБ” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа 2019 оны 8-р сарын 13-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд дараах үр дүнд хүрчээ. Үүнд:

-Харилцагчийн тоо өмнөх оны мөн үеэс 170 хувиар өсөж 4,712 тэрбум төгрөг зээлийн багц 103 хувиар өсөж 52.9 тэрбум төгрөгт тус тус хүрлээ.

-Нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 35 тэрбум төгрөгөөр буюу 117 хувиар өсөж, 65.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

-Нийт өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24 тэрбум төгрөгөөр өсөж 35.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

-8.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн ба нийт орлого өмнөх оны мөн үеэс даруй 68 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2019 оны эхний хагас жилд 4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 56 хувиар өссөн үзүүлэлт болжээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Сүү” ХК санхүү, үйл ажиллагааны тайлангаа нээлттэй танилцууллаа

Монголын Хөрөнгийн Биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “Сүү” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа 8-р сарын 13-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. 2019 оны эхний хагас жилд “Сүү” ХК үйл ажиллагаагаа сайжруулах, шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлэх, үйлдвэрийн их засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Тайлант хугацаанд хүрсэн үр дүнг 2018 оны эхний хагас жилийн мөн үетэй харьцуулан танилцуулахад:

-Бэлтгэн нийлүүлэгчдээс 8.35 сая литр буюу 9.1 тэрбум төгрөгийн түүхий эд татан авч сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь сүү бэлтгэлийн биет дүн 4%, мөнгөн дүн 3%-аар тус тус өссөн үзүүлэлт болсон байна.

-Борлуулалтын биет дүн 14.8 мянган тонн бүтээгдэхүүнд хүрч 8% өссөн, цэвэр борлуулалт 36.5 тэрбум төгрөгт хүрч, 5% өссөн бөгөөд цэвэр ашиг 71%-аар өсөж 4.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

-2019 оны эхний хагас жилийн томоохон хөрөнгө оруулалтыг танилцуулбал: PET савлагааны шугамд 5.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 100% хийж гүйцэтгэснээс гадна парк шинэчлэлийн хүрээнд борлуулалтын 3, сүү бэлтгэлийн 7 автомашинд нийт 920 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Түүнчлэн, ERP буюу байгууллагын нөөц төлөвлөлтийн систем нэвтрүүлэх ажлын хүрээнд 88 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

-PET шугамаар орчин үеийн хэрэглэгчдийн амьдралын хэв маягт тохиромжтой, авч явахад авсаархан, 290 гр болон 870 гр-ын савлагаа бүхий цөцгийтэй, хад, гүзээлзгэнэ жимстэй “Амтлаг” брэндийн тараг үйлдвэрлэн, зах зээлд амжилттай нэвтрүүллээ.

-ЕСБХБ болон бусад зөвлөх компаниудтай хамтран компанийн засаглалыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Ирэх улирлуудад сүү хүлээн авах, боловсруулах цехийн төслийг хэрэгжүүлэх, агуулах, авто гаражийн барилгын шинэчлэл, борлуулалтын нэг цэгт хүрэх давтамжийг нэмэгдүүлэх, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн зах зээлд гаргахаар ажиллаж байгаа тухай танилцууллаа.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ҮСХ: Төмрийн хүдрийн экспорт 72%-аар өсөв

Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлт оны эхний долоон сарын байдлаар 8.1 тэрбум ам.доллартай тэнцэж өнгөрсөн оны мөн үеийнхээс 9.4%-аар нэмэгдсэн дүнтэй гарсныг Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Үүнээс экспорт 4.6 тэрбум ам.доллар, импорт 3.5 тэрбум ам.долларыг эзэлж байна. Экспортын хувьд авч үзвэл өнгөрсөн оны мөн үеийнхээс 11%, импорт 7.4%-аар тус тус нэмэгдсэн байна.

Нийт экспортын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг эрдсийн экспорт оны эхний долоон сард 3833.8 сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9.5%-аар өссөн дүн боллоо.

Эрдсийн экспорт дундаа нүүрсний экспортын дүн 1.79 тэрбум ам.долларыг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал орлогын дүн 10.6%-аар нэмэгдсэн гэсэн үг. Оны эхний долоон сарын байдлаар нүүрсний экспортын биет жин 20.9 сая тоннд хүрсэн нь өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдсан дүнтэй гарч байна.

Орлогын дүнгээр хоёрдугаарт эрэмбэлэгдэж байгаа зэсийн баяжмалын экспорт оны эхний долоон сарын байдлаар 1.19 тэрбум ам.доллартай тэнцэж, 2%-аар өссөн дүнтэй гарлаа. Мөн биет жингээр 867.7 мянган тоннд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2.3%-аар өссөн байна. Харин боловсруулсан цэвэр зэсийн экспорт 5.1 мянган тоннд хүрч, орлогын дүнгээр 30.5 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс жингийн хувьд 33.7%, орлогын тухайд 40.7%-аар тус тус буурчээ.

Төмрийн хүдрийн экспорт мөн хугацаанд 311.3 сая ам.доллартай тэнцэж, жингээр 4.83 сая тоннд хүрчээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад жингээр 22.1%-аар, орлогын дүнгээр 71.6%-аар тус тус өссөн гэсэн үг. Төмрийн хүдрийн үнэ дэлхийн зах зээлд огцом өсөлттэй байгаа нь экспортын орлого нэмэгдэх нөхцөл болж байна.

Түүхий газрын тосны экспорт оны эхний долоон сарын байдлаар 3.85 сая баррельтай тэнцэж 210.5 сая ам.долларын орлого бүрдүүлжээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад газрын тосны экспортын орлого 16.1%-аар, жингийн хувьд 3.2%-аар буурсан дүнтэй гарсан гэсэн үг.

Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтны экспорт мөн хугацаанд 196 орчим сая ам.доллар буюу 4.7 тоннд хүрчээ. Энэ нь орлого болон жингийн хувьд өнгөрсөн оны мөн үеийнхээс 35-36%-аар нэмэгдсэн гэсэн үг. Монголбанкны мэдээлж буйгаар оны эхний долоон сарын байдлаар алтны нийт худалдан авалт 7.5 тоннд хүрээд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 19%-аар буурчээ.

Цайрын хүдэр, баяжмалын экспорт оны эхний долоон сарын байдлаар 82.8 мянган тоннд хүрч, орлогын дүн нь 121.5 сая ам.доллартай тэнцлээ. Энэ нь орлогын дүнгээр 1.8%-аар буурсан бол жингээр 16.1%-аар өссөн гэсэн үг.

Жоншны хүдэр, баяжмалын экспорт мөн хугацаанд 359.1 мянган тоннд хүрч, 115 орчим сая ам.долларын орлого олжээ. Тодруулбал орлогын хувьд 44.7%-аар, жингийн хувьд 49.7%-аар тус тус нэмэгдсэн байна.

Хар тугалганы хүдэр, баяжмалын экспорт мөн хугацаанд 14 мянган тоннд хүрч, 30.5 сая ам.доллартай тэнцлээ. Энэ нь жингийн хувьд 26.1%-аар, орлогын хувьд 6.1%-аар тус тус өссөн гэсэн үг.

Молибденийн баяжмалын экспортын хувьд оны эхний долоон сарын байдлаар 3.3 мянган тоннд хүрч, орлогын дүн нь 29.1 сая ам.доллартай тэнцлээ. Энэ нь орлогын дүнгээр 8.1%-аар нэмэгдсэн боловч, жингээр ялимгүй буурсныг илтгэнэ.

Гянтболдын хүдэр, баяжмалын экспорт мөн хугацаанд 275.2 тоннд хүрч, 2.9 сая ам.долларт хүрсэн нь жингээр 4.9%, орлогын хувьд 12%-аар тус тус буурсан гэсэн үг.

Ийнхүү эрдсийн экспортыг задалж үзвэл төмрийн хүдэр, жоншны хүдэр, баяжмалын экспорт нэлээд өсөлттэй байсан бол газрын тос, цэвэр зэсийн экспорт багагүй буурлаа. Улсын нийт экспортыг сарын дүнгээр авч үзвэл долдугаар сарын экспорт 632.5 сая ам.долларт хүрч өмнөх сарынхаасаа 43.1 сая ам.доллараар буурсан байна. Харин долдугаар сарын импорт 613.4 сая ам.долларт хүрч 34.7 сая доллараар өсчээ.

Гадаад худалдааны ашиг оны эхний долоон сарын байдлаар 1.1 тэрбум ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 213.3 сая ам.доллараар нэмэгдсэн дүнтэй гарлаа.

Эх сурвалж: MongolianMiningJournal.mn

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөл Асгатын мөнгөний ордод ажиллалаа

Засгийн газраас “Монголросцветмет” ТӨҮГ-ын мэдэлд байсан Асгатын мөнгөний ордыг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлсний дагуу өнгөрсөн зургаадугаар сард Ашигт малтмал, газрын тосны газраас уг ордын ашиглалтын дөрвөн тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн юм. Тэгвэл “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөл Ашигт малтмал, газрын тосны газар болон Онцгой байдлын ерөнхий газрын алба хаагчидтай хамтран Асгатын мөнгөний ордын өнөөгийн нөхцөл байдалтай танилцаж, уг ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг судлахаар ажиллав. Тэд ордоос технологийн дээж авах, замын нөхцөл байдал, уурхайн хэвтээ амуудад нэвтрэх боломжийг судаллаа.

Энэ үеэр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Уул уурхай, техник, технологийн газрын захирал Б.Элбэгзаяа тэргүүтэй төлөөлөл Баян-Өлгий аймгийн удирдлагуудтай уулзаж, уг ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар санал бодлоо солилцов. Баян-Өлгий аймгийн ИТХ-ын дарга Д.Бауыржан уг ордыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар орон нутгийн төсөвт дэмжлэг болж, иргэдийг ажлын байраар хангах боломжтой болж буйг дурдаад аймгийн удирдлага бүхий л талаар дэмжиж, хамтран ажиллахаа илэрхийлсэн юм.

Эх сурвалж: Montsame.mn



Хятадын төмрийн хүдрийн импорт 21%-аар өсжээ

Хятад улс долдугаар сард 91.02 сая тонн төмрийн хүдэр импортолсон нь өмнөх сарынхаас 21%-аар өсжээ. Энэ нь он гарснаас хойших хамгийн өндөр хэмжээнд тооцогдож буйг тус улсын Гаалийн ерөнхий газраас мэдээллээ.

Энэ оны эхний долоон сарын байдлаар нийт 590.1 сая тонн төмрийн хүдэр импортолсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.9%-аар буурчээ. Өнгөрсөн долоо хоногт Даляны түүхий эдийн бирж дээр төмрийн хүдрийн үнэ буурч 1 тонн нь 689 юань буюу 97.7 ам.доллар хүрсэн байна.

Эх сурвалж: MongolianMiningJournal.mn

БУСАД МЭДЭЭ

Монгол улсын эдийн засгийн 2019 оны 7-р сарын байдал

Мөнгө, зээл

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 7 дугаар сарын эцэст 20.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 44.1 (0.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.1 (17.8%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 7 дугаар сарын эцэст 935.0 тэрбумтөгрөг болж, өмнөх сараас 2.1 (0.2%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 17.9 (1.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 7 дугаар сарын эцэст 18.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 62.6 (0.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 2.7 (17.2%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 7 дугаар сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 19.7 (1.0%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 601.8 (45.2%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.1 пунктээр өссөн байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш 2019 оны 7 дугаар сард 2 661.55 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар, өмнөх сараас 0.3 хувиар тус тус суларсан байна. Монголбанкнаас зарласан төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2019 оны 7 дугаар сард 386.98 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар, өмнөх сараас 0.6 хувиар тус тус суларсан байна. Монголбанкнаас зарласан төгрөгийн рубльтай харьцах сарын дундаж ханш 2019 оны 7 дугаар сард 42.06 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар, өмнөх сараас 1.6 хувиар тус тус суларсан байна.

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 6.0 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 5.5 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 535.3 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 7 дугаар сард 1134.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 186.1 (19.6%) тэрбум төгрөгөөр өсөж, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 791.5 тэрбум төгрөг болж, 110.9 (12.3%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 80.9 хувийг татварын орлого, 8.1 хувийг татварын бус орлого, 10.5 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 0.5 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 82.1 хувь, хөрөнгийн зардал 15.8 хувь, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2.1 хувийг эзэлж байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 639.4 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 138.7 сая америк доллараар буурчээ.

Урсгал данс 683.6 сая америк долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 898.3 сая америк доллар, анхдагч орлогын данс 754.8 сая америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн данс 2019 оны эхний хагас жилд 44.2 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 2.5 (5.9%) сая америк доллараар өссөн байна. Харин санхүүгийн дансны тэнцэл 1.1 тэрбум америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 419.4 (64.3%) сая америк доллараар өсжээ.

Төлбөрийн тэнцэл 2018 оны эхний хагас жилд 141.7 сая америк долларын алдагдалтай гарч байсан бол 2019 оны хагас жилд өмнөх оны мөн үеэс 627.9 сая америк доллараар өсөж, 456 сая америк долларын ашигтай гарлаа.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 7 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.1 хувиар буурч, өмнөх оны эцсээс 4.8 хувь, өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.5 хувь (мах, махан бүтээгдхүүний дэд бүлгийн үнэ 29.2 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.2 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 9.7 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 2.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 9.1 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 10.8 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 8.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 7 дугаар сард өмнөх оны эцсээс 4.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 13.9 хувь (мах, махан бүтээгдэхүүн 38.7 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 7 дугаар сард өмнөх сараас 0.1 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 1.5 хувь), тээврийн бүлгийн үнэ 0.4 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод 2019 оны 7 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 23.8 хувь буюу 82 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 7.6 хувь буюу 26 бараа, үйлчилгээний үнэ буурч, 68.6 хувь буюу 236 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 47 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргажгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.